

НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 4 САРЫН ТАЙЛАН

Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Сүхбаатар аймгийн харьяат Нийслэлийн 31 дүгээр сургуулийн 10-р ангийн сурагч Э. Энхтулгын НОМИН-ЭРДЭНЭ охины "ӨВЛИЙН ЦАГ АГААР ЧИ..." шинэ номын нээлтийг зохион байгууллаа. Уг нээлтийн арга хэмжээнд МЗЭ-ийн Сүхбаатар аймаг дахь салбар зөвлөлийн төлөөлөгчид, ахмад номын санчид, СУГ-ын мэргэжилтнүүд, ЕБС-ийн номын санчид, хүүхэд багачууд, номын клубын нийт 100 гаруй сурагчид оролцлоо. Мөн номын зохиогч, уншигчийн уулзалтыг хийж, шүлэг яруу найраг сонирхдог хүүхэд багачууд шүлэг уншиж сонирхуулж, зохиогч гарын үсэгтэй номоо дурсгав.



"ДЭЛХИЙН НОМЫН ӨДӨР"-ийг угтан "Чанга" уншлагаар "Заанаас өндөр хүн" номыг уншиж, "Өнхрүүшхэн" үлгэрээр Хуруун хүүхэлдэйгээр дүрийн тоглолтыг 7-р цэцэрлэгийн Урансайхан, Чулуунцэцэг багштай ахлах ангийн 25 хүүхдэд үзүүллээ. Мөн дэлхийн шилдэг "Шинэ ном"-оор номын үзэсгэлэн гаргалаа.



"ДЭЛХИЙН НОМЫН ӨДӨР"-т зориулсан хүүхдийн шилдэг номын үзэсгэлэн
ХҮҮХДИЙН УНШЛАГЫН ТАНХИМААС



Номын сангийн зочин подкаст анхны дугаараар захирал Х. Мөнгөн-Өлзий оролцлоо.

Аймгийн Нийтийн номын сангаас Түвшинширээ суманд очиж, хүүхэд багачуудад "Ном унших дадал" сэдвээр мэдээлэл өгч, харилцан ярилцаж, танин мэдэхүйн "АХА" тэмцээнийг зохион явуулахад 300 гаруй сурагчид хамрагдлаа. Шалгарсан хүүхдүүдийг номоор шагнаж урамшуулав.



ХАБЭА-н сарын аяны хугацаанд ажилчин албан хаагчид болон хүүхдүүдээ витаминжууллаа.



Хүүхдэд ээлтэй жилийн хүрээнд "Хүүхдийг зодож шийдэхийн эсрэг олон улсын өдөр 4 сарын 30 нд болдог .Үүнтэй холбоотой хүүхдийн танхимд ирсэн хүүхдүүдэд гарын авлага тарааж, сурталчиллаа. Мөн цахимаар сурталчилан таниулж байна.



Статистак мэдээ:

Байнгын уншигч-249, ирэгсэд-1467, ном олголт 1946